



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/164

Ховд

Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн
төлбөрийг зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөр төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж буй иргэдээс 2024 онд төвлөрсөн 131,313,255.00 (нэг зуун гучин нэгэн сая гурван зуун арван гурван мянга хоёр зуун тавин тав) төгрөгийн 50 хувь болох 65,656,662.00 (жаран таван сая зургаан зуун тавин зургаан мянга зургаан зуун жаран хоёр) төгрөгийг Батлан хамгаалахын сайдтай байгуулсан гэрээний дагуу Сангийн яамны Төв төрийн сангийн 100900000704 тоот дансанд шилжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батнасан)-д зөвшөөрсүгэй.

2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан иргэдийн мөнгөн төлбөрийн орлогын 50 хувь болох 65,656,662.00 (жаран таван сая зургаан зуун тавин зургаан мянга зургаан зуун жаран хоёр) төгрөгийг орон нутгийн төрийн сангийн тусгай дансанд төвлөрүүлэн байршуулж, Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг орон нутагт сурталчлах, хэрэгжилтийг хангах, цэргийн штабын бэлэн байдал, үндсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах чиглэлээр зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (хурандаа Б.Ганхуяг)-д даалгасугай.

3. Орон нутгийн тусгай дансанд төвлөрсөн мөнгөн төлбөрийн зарцуулалтын хуваарийг хавсралтаар баталсугай.

4. Орон нутгийн тусгай дансанд төвлөрсөн мөнгөн төлбөрийг захиран зарцуулсан тайланг цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан ажлын гүйцэтгэлийн хамт тусгай маягтын дагуу гаргаж, Батлан хамгаалах яамны Орон нутгийн хамгаалал, дайчилгааны газарт хүргүүлэн тооцоо хийж, ажлын үр дүнг танилцуулахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (хурандаа Б.Ганхуяг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.АМАРСАНАА



8400001 2690

Zah A/164 Kh